



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 20 өдөр

Дугаар A/246

Улаанбаатар хот

Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүн,  
чиг үүрэг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, "Монгол Улсын эхийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд шинэчлэлийг нэвтрүүлэх нь - Туршилтаас тогтолцоог бүрдүүлэх нь" төслийн баримт бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангаас санхүүжүүлж, хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсын эхийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд шинэчлэлийг нэвтрүүлэх нь - Туршилтаас тогтолцоог бүрдүүлэх нь" төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, чиг үргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төслийн удирдах хорооны үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, үйл ажиллагааны зохицуулалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газартай хамтран хэрэгжүүлэх, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнг тооцож ажиллахыг Удирдах хорооны дарга, Эрүүл мэндийн дэд сайд /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.


3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/210 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080794



**“МОНГОЛ УЛСЫН ЭХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД  
ШИНЭЧЛЭЛИЙГ НЭВТРҮҮЛЭХ НЬ - ТУРШИЛТААС ТОГТОЛЦОOG БҮРДҮҮЛЭХ  
НЬ” ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: Эрүүл мэндийн дэд сайд
- Дэд дарга: Люксембургийн Их Гүнт Улсын Гадаад хэргийн яамны төлөөлөл
- Нарийн бичгийн дарга: Төслийн менежер
- Гишүүд:  
Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;  
Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга;  
Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусlamжийн газрын дарга;  
Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга;  
Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга;  
Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирал;  
Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга;  
Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга /зөвшилцөнөөр/;  
Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын төлөөлөл /зөвшилцөнөөр/;  
НҮБ-ын Хүн амын сангийн Суурин төлөөлөгч

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 06 сарын 20-ны өдрийн  
А. дугаар тушаалын 2 дугаар хавсралт  
246



**“МОНГОЛ УЛСЫН ЭХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД  
ШИНЭЧЛЭЛИЙГ НЭВТРҮҮЛЭХ НЬ - ТУРШИЛТААС ТОГТОЛЦООГ  
БҮРДҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ**

“Монгол улсын эхийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээнд шинэчлэлийг нэвтрүүлэх нь - туршилтаас тогтолцоог бүрдүүлэх нь” Төслийн удирдах хороо (ТУХ) нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, Монгол Улсын Засгийн газар болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн хооронд байгуулагдсан Улс орныг дэмжих хөтөлбөр (2017-2021)-т нийцүүлэн дараах чиг үүрэгтэйгээр ажиллана.

1. Төслийг стратегийн ерөнхий удирдлага, төслийн салбар дундын зохицуулалтаар хангах;
2. Төслийн баримт бичигт хийгдэх томоохон өөрчлөлтийг үнэлэх, батлах;
3. Жилийн ажлын төлөвлөгөө, холбогдох төсвийг батлах, дүгнэх, жилийн явцын тайланг баталгаажуулах;
4. Төслийн үйл ажиллагааг холбогдох олон улсын болон үндэсний стратеги, хөтөлбөр, төслүүдтэй уялдуулах, зохицуулалтыг хангахад дэмжлэг үзүүлэх, тодорхой тулгамдсан асуудлыг авч шийдвэрлэх;
5. Төслийн баг нь ТУХ-ны ажлын албаны үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Эрүүл мэндийн яам, НҮБ-ын Хүн амын сангийн нэрийн өмнөөс хурлаар хэлэлцэх асуудал, хөтөлбөрийг бэлтгэх, холбогдох баримт бичиг, урилга илгээх, мөн хурлын тэмдэглэлийг хөтлөх ажлыг гүйцэтгэнэ.
6. Төслийн баг нь ТУХ-ны хурлын хэлэлцэх асуудал, дэмжлэг үзүүлэх бусад баримт бичгийг хорооны бүх гишүүдэд ажлын 3 хоногоос доошгүй хугацааны өмнө илгээнэ. Хурлын тэмдэглэлийг ТУХ-ны дарга батлах бөгөөд уулзалтын дараах 5 хоногийн дотор түгээнэ.
7. Эрүүл мэндийн дэд сайд нь ТУХ-ны даргын хувьд төсөл хэрэгжүүлэх багийн бэлтгэсэн үр дүнгийн мэдээлэлд үндэслэн Эрүүл мэндийн сайд, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар болон холбогдох бусад түншүүдэд төслийн ахиц дэвшил, хэрэгжилтийн талаар тайлagnаж байна.
8. ТУХ нь төслийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжүүлэлтэд тулгарч болзошгүй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор жилд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай бол, ТУХ-ны ээлжит бус хурлыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн төслийн баг болон Эрүүл мэндийн яамны хүсэлтээр зохион байгуулж болно.

9. Удирдах хорооны гишүүд төслийн ажлын төлөвлөгөөнд батлагдсан, мөн төслийн хүрээнд хамаарах гадаад болон дотоодод зохион байгуулагдах аливаа арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцно.

10. ТУХ-ны хурлын ирц нь түүний гишүүн байгууллагуудын дөрөвний гурваас доошгүй байх ёстай. ТУХ нь зөвшилцлийн замаар шийдвэр гаргана. Харин зөвшилцэл амжилтгүй болсон тохиолдолд гишүүн байгууллагуудын олонхийн саналаар шийдвэр гаргаж болно.

11. Байгууллага бүр саналын нэг эрхтэй байна. Хуралд оролцоогүй ч зохих зөвшөөрлийн үндсэн дээр гишүүн байгууллагын бичгээр ирүүлсэн санал хүчин төгөлдөр байна. Зохих зөвшөөрөлгүйгээр ирүүлсэн санал, эсхүл шийдвэрийг эс зөвшөөрсөн гишүүн байгууллагуудын санал, мөн хуралд оролцохос татгалзсан зэргийг эсрэг санал өгсөнд тооцно.

12. ТУХ-ны хурлын материал нь хурлаар хэлэлцэх асуудал, танилцуулгууд, Удирдах хорооны хэлэлцүүлэгт шаардлагатай нэмэлт, дэмжлэг баримт бичгүүд, төсөл хэрэгжүүлэгч нэгжээс ирүүлсэн мэдээлэл, улирал тутмын явцын мэдээлэл, уулзалтын шийдвэрийн төсөл зэргээс бүрдэнэ.

13. ТУХ-ны хурлын шийдвэр нь зөвлөмж болон тэмдэглэл хэлбэртэй байна.

14. ТУХ-ны хурлын шийдвэрийг заавал, бүрэн хэрэгжүүлнэ.

15. ТУХ-ны хурлын шийдвэрийг үндэслэн засгийн газрын байгууллагууд, албан тушаалтууд батлагдсан жилийн ажлын төлөвлөгөө, зохих дүрэм журмын дагуу өөрсдийн эрх хэмжээ, үүрэг хариуцлагын хүрээнд шийдвэр гаргаж, хэрэгжүүлнэ.

16. Ажлын алба нь уулзалтын нарийвчилсан тэмдэглэлийг боловсруулж, албажуулах үүрэг хүлээнэ.

17. ТУХ-ны хурал болсноос хойш ажлын 10 хоногийн дотор ТУХ-ны гишүүдийн саналыг авахаар хурлын тэмдэглэлийн төслийг илгээх бөгөөд үүний дараагаар хоёр долоо хоногийн дотор ТУХ-ны дарга баталсан байна.

18. ТУХ-ны бүх гишүүд хурлаас гаргасан шийдвэрийн өмнөөс хамтын хариуцлага хүлээнэ.

19. Хариуцсан байгууллага, албан тушаалтан нь ТУХ-ны шийдвэрийн хэрэгжилтийн байдал, ахицын талаар заасан хугацааны дотор мэдээлэх, эргэн тайлагнах үүрэг хүлээнэ.

20. ТУХ нь шаардлагатай тохиолдолд гишүүнчлэл болон энэхүү удирдамжийг өөрчлөх талаар санал гаргаж болно.